

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2024/09/НА-СТА-ТТЗ

Чингис хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Б.Хуланхатан Утас: 99008827 Цахим хаяг: khulankhatanb@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2024.03.25 № 402
танай _____ -ны № _____ -т

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТШИРЭЭТ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Г.ГАНСҮХ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Батширээт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 1,535,165.8 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө, 269,895.1 мянган төгрөгийн авлага, 114,912.2 мянган төгрөгийн урьдчилгаа, 120,534.2 мянган төгрөгийн бараа материал, 10,710.0 мянган төгрөгийн нөөцийн бараа, 1,980,620.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй, нийт хөрөнгө 4,030,838.2 мянган төгрөг байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 592,539.1 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, 1,346,422.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төсвийн байгууллагуудад 2,022,199.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос ерөнхий орлогын дансанд 218,439.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Нэмэлт санхүүжилтийн дансанд 588,769.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 582,866.8 мянган төгрөгийг зарцуулан үлдэгдэл 5,902.8 мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

232429500

Аудитын гол асуудал

Батширээт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайланг 8,611.0 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж хуулийн хугацаанд ирүүлэх, үйл ажиллагаа явуулахгүй, татан буулгахаар шийдвэрлэсэн Хавтгарын хөгжил ОНӨААТҮГ, Батширээт сум тохижилт ОНӨААТҮГ-ыг улсын бүртгэлээс хасуулах арга хэмжээ авах, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдлийг барагдуулахад анхаарч ажиллах шаардлагатай.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөг/

Код	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,559,496.90	2,050,217.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,135,596.80	1,534,165.80
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	275,043.20	269,895.10
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	63,338.80	114,912.20
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	75,956.20	120,534.20
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	9,562.00	10,710.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,856,748.70	1,980,620.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,856,748.70	1,980,620.80
39200	Биет хөрөнгө		1,751,311.90	1,717,474.00
39300	Биет бус хөрөнгө	13	105,436.80	263,146.80
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		3,416,245.60	4,030,838.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		4,592.60	20,091.30
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	4,592.60	20,091.30
41300	Өглөг	17а, 17б	4,592.60	20,091.30
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,411,653.00	4,010,747.00
51	Засгийн газрын хувь оролцоо		3,411,653.00	4,010,747.00
51100	Засгийн газрын оруулсан капитал		498,678.10	656,388.10
51200	Хуримтлагдсан үр дүн		2,550,067.10	3,027,396.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		362,907.80	326,962.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		3,416,245.60	4,030,838.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		4,405,912.00	4,857,126.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО		1,046,328.60	1,175,227.00
110	Орлогын албан татвар		231,459.00	258,918.00
1100	Хувь хүний орлогын албан татвар		231,459.00	258,918.00
113	Хөрөнгийн албан татвар		58,243.60	57,133.10
118	Бусад татвар, төлбөр, хураамж		756,626.10	859,176.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	604,901.60	527,814.40
120	Нийтлэг татварын бус орлого		604,901.60	527,814.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,754,681.90	3,154,085.10
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	3,335,196.40	4,171,483.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,335,196.40	4,171,483.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,440,137.20	1,921,535.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		356,385.10	546,371.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		50,755.50	69,474.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		336,575.00	54,883.80
2104	Хангамж, бараа материалын зардал		60,755.50	45,533.00
2105	Нормативт зардал		900.00	4,980.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		94,008.10	18,109.50
2107	Томилолт, зочны зардал		13,586.00	30,206.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		284,347.00	864,010.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		242,824.80	287,966.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,895,059.20	2,249,948.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,070,715.60	685,642.80
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		4,569,516.00	244,258.80
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		(3,498,800.30)	441,384.00

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,859,644.70	6,859,644.70
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	50,808.60	50,808.60
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,910,453.30	6,910,453.30
9	Тайлант үеийн үр дүн	(3,498,800.30)	(3,498,800.30)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,411,653.00	3,411,653.00
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,411,653.00	3,411,653.00
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	35,945.20	35,945.20
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,447,598.20	3,447,598.20
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(35,945.20)	(35,945.20)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	157,710.00	157,710.00
19	Тайлант үеийн үр дүн	441,384.00	441,384.00
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	4,010,747.00	4,010,747.00

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,077,827.60	5,914,094.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,046,328.60	1,175,227.00
110	Орлогын албан татвар	231,459.00	258,918.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	231,459.00	258,918.00
113	Хөрөнгийн албан татвар	58,243.60	57,133.10
118	Бусад татвар, төлбөр, хураамж	756,626.10	859,176.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	18,119.10	33,117.60
1181	Газрын төлбөр	6,678.20	14,665.90
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	731,828.80	811,392.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	276,817.10	1,035,509.80
120	Нийтлэг татварын бус орлого	276,817.10	1,035,509.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,754,681.90	3,703,357.70
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,211,540.00	5,178,514.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,211,540.00	5,178,514.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,308,644.90	2,922,336.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	408,139.70	567,413.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,437.00	82,529.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	339,107.40	59,713.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,192.70	56,894.40
2105	Нормативт зардал	900.00	1,507.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	103,011.40	19,009.50
2107	Томилолт, зочны зардал	13,586.00	28,526.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	197,208.10	1,482,519.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,062.60	624,222.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,902,895.20	2,256,177.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	866,287.60	735,580.50
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	658,736.10	337,011.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	658,736.10	337,011.40
2200	Дотоод эх үүсвэрээр	658,736.10	337,011.40
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(658,736.10)	(337,011.40)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	207,551.50	398,569.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	928,045.30	1,135,596.80
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,135,596.80	1,534,165.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,433,149.20	1,963,007.77	470,141.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,842,548.70	1,682,999.33	159,549.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,810,704.70	1,673,363.33	137,341.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	584,208.50	547,741.92	36,466.58
210101	Үндсэн цалин	383,464.50	336,722.53	46,741.97
210102	Нэмэгдэл	144,863.10	110,811.70	34,051.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,782.60	41,501.85	(29,719.25)
210104	Урамшуулал	8,800.00	46,478.35	(37,678.35)
210105	Гэрээт ажлын хөлс	35,298.30	12,227.48	23,070.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,024.90	69,443.91	5,580.99
210201	Тэтгэврийн даатгал	51,653.20	48,632.80	3,020.40
210202	Тэтгэмжийн даатгал	5,842.90	6,620.81	(777.91)
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,674.40	3,792.32	882.08
210204	Ажилгүйдлийн даатгал	1,168.50	916.50	252.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,685.90	9,481.48	2,204.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	399,425.60	377,938.44	21,487.16
210301	Гэрэл, цахилгаан	45,760.80	35,393.09	10,367.71
210302	Түлш, халаалт	345,978.80	336,745.35	9,233.45
210303	Цэвэр, бохир ус	7,686.00	5,800.00	1,886.00
2104	Хангамж, бараа материалын зардал	44,332.70	43,682.15	650.55
210401	Бичиг хэрэг	4,566.00	4,753.70	(187.70)
210402	Тээвэр, шатахуун	34,749.70	34,605.99	143.71
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,686.40	2,581.46	104.94
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,330.60	1,741.00	589.60
2105	Нормативт зардал	1,855.20	1,507.50	347.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,855.20	1,507.50	347.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	77,346.90	76,899.05	447.85
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,723.90	2,438.50	285.40
210602	Тавилга	5,297.50	5,297.20	0.30
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1.50	-	1.50
210604	Урсгал засвар	69,324.00	69,163.35	160.65
2107	Томилолт, зочны зардал	28,800.00	28,526.60	273.40
210702	Дотоод албан томилолт	28,800.00	28,526.60	273.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	534,826.90	464,491.88	70,335.02
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	530,631.40	460,729.87	69,901.53
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	383.80	-	383.80
210803	Даатгалын үйлчилгээ	1,050.50	1,050.10	0.40
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,723.50	1,681.80	41.70
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35.60	33.00	2.60
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	599.40	599.20	0.20
210807	Газрын төлбөр	402.70	397.91	4.79
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,884.00	63,131.89	1,752.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,439.00	59,692.28	1,746.72
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,445.00	3,439.61	5.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,844.00	9,636.00	22,208.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	9,912.00	4,724.00	5,188.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	9,912.00	4,724.00	5,188.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,932.00	4,912.00	17,020.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,932.00	-	16,932.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000.00	4,912.00	88.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	481,600.50	280,008.44	201,592.06
223001	Бусад хөрөнгө	481,600.50	280,008.44	201,592.06
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	109,000.00	-	109,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	109,000.00	-	109,000.00

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,433,149.20	2,303,181.48	129,967.72
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,265,249.20	2,255,937.50	9,311.70
320001	Орон нутгийн төсвөөс	1,983,848.70	1,974,537.00	9,311.70
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	281,400.50	281,400.50	-
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	167,900.00	47,243.99	120,656.01
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	60,000.00	28,288.99	31,711.01
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,400.00	18,955.00	(6,555.00)
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	95,500.00	-	95,500.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	117,479.88	(117,479.88)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□		285,881.72	(285,881.72)

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	588,769.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	588,769.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	582,866.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	420.00
210302	Түлш, халаалт	420.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,386.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,386.21
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	560,060.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	560,060.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,902.82
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,902.82
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,902.82
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	588,769.63
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	588,769.63
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,810.13
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	579,959.50

Гурав. Аудитын илрүүлэлт: Батширээт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн төсвийн 6 байгууллага, 1 төрийн сан, 4 тусгай сан, 4 орон нутгийн өмчит нийт 15 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад санал дүгнэлт гаргаж 4 байгууллагын санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан ЕБС-д “ИХНАЯД АУДИТ” ХХК аудит хийж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт, аймаг дахь Төрийн аудитын газар ЭМТ, Хүүхдийн цэцэрлэг, ЗДТГ, Батширээт СДОА -д “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн.

3.1 Тус сумын харьяа орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн талаар

Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 774,145.0 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулсан. Үүнд:

1. ЗДТГ -ын санхүүгийн тайланд 229,025.0 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав.
 - Байгаль орчин нөхөн сэргээх зардлаас гаргасан гэрээт ажлын урьдчилгаа 62,612.2 мянган төгрөгийг зардалд хаасан.
 - Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 3,923.2 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 4,779.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.
 - Үндсэн хөрөнгийн дансанд 157,710.0 мянган төгрөгийн бусад биет бус хөрөнгийг бүртгээгүй.
2. Батширээт СДОА-ын санхүүгийн тайланд 545,120.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.
 - Орлогын дэлгэрэнгүй тайланд дуудлага худалдааны дэнчингийн төлбөр 545,120.0 мянган төгрөгийг орлогоор тайлагнасан.

Аудитаар зөрчил² илрээгүй.

Улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 624,236.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 622,365.1 мянган төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж, 1,871.8 мянган төгрөгийг зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах 1 зөвлөмж өгсөн байна. Үүнд:

1. Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланд 26,271.0 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 1,871.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.
 - Тайлант үеийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 5,013.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулав.
 - Урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлогыг 21,258.0 мянган төгрөгөөр дутуу, орон нутгийн тогтмол зардлын санхүүжилтийн орлогыг 21,258 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг залруулав.
 - Анхан шатны баримтыг үндэслэж нягтлан бодох бүртгэлийг хөтлөөгүйгээс цалингийн зардлыг үр дүнгийн тайланд 1,871.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тусган илэрхийлсэн.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Соёлын төвийн санхүүгийн тайланд 14,000.0 мянган төгрөгийн урьдчилж гарсан зардлыг хүлээн зөвшөөрч хаахдаа өмнөх үеийн үр дүнг бууруулсан, үндсэн хөрөнгө дансанд орлого авсан биет бус бусад хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэн 1 алдааг аудитын явцад залруулсан.
3. Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд 582,094.1 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулав.
 - Орон нутгийн төсвийн 51,716.2 мянган төгрөгийн санхүүжилтийн орлогыг, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон 520,110.5 мянган төгрөгийн санхүүжилтийг орлогын ангилал зөрүүлэн бүртгэсэн.
 - Төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгийн төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг 8,782.4 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.
 - Хөрөнгийг данснаас хассан гарзыг 1485.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.
4. ЕБС-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 46 нэр төрлийн хөрөнгийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй 1 зөрчил илэрч 1 зөвлөмж өгсөн байна.

Батширээт сумын Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 8,611.0 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулсан.

3.2 Төлбөрийн акт

Байхгүй

3.3 Албан шаардлага

Байхгүй.

3.4 Зөвлөмж

Байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	1	8,611.0			1	8,611.0	1	8,611.0				
ЗДТГ	4	229,025.0	1	157,710.00	3	71,315.0	4	229,025.0				
Батширээт СДОА	1	545,120.0			1	545,120.0	1	545,120.0				
Дүн	6	782,756.0	1	157,710.00	5	625,046.0	6	782,756.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах		Хууль, хяналтын байгууллагад	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	-	-										
	-	-										
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	10	4	4	2	4			
2	ОНӨААН	4	1	1	2	1			
3	ТТЗ	1	1			1			
	НИЙТ	15	6	5	4	6			